



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/526

Улаанбаатар хот

**Албан хаагчдын гүйцэтгэлийн тайлан болон
хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэж,
урамшуулал олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, 52 дугаар зүйлийн 52.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэг, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2.5.2 дахь заалт, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 9.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Байгууллагын албан хаагчдын 2020 оны 4 дүгээр улирлын ажлын үр дүн, гүйцэтгэлийн тайлан болон хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ “бүрэн хангалттай”, “хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн албан хаагчдыг хавсралтад зааснаар урамшуулсугай.

2. Урамшууллыг зохих сангаас олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Тушаал-2020

115060001348